

Банкны салбарын эргэн тойронд

04.08 – Худалдаа Хөгжлийн банк төгрөгийн олон улсын виза карт буюу банкин дахь төгрөгийн данснаасаа доллараар төлбөр төлөх, онлайн худалдан авалт хийх боломжтой виза картыг шинээр гаргалаа. <http://www.tdbm.mn/mn/1813/news>

04.27 - Монгол Улсын засгийн газар болон МҮХАҮТ хамтран жил бүр шалгаруулдаг Монгол Улсын “ТОП-100” аж ахуйн нэгжид Хаан банк, ХХБ, Голомт банк, Төрийн банк, Хас банк, Улаанбаатар хотын банк болон Капитал банк зэрэг 7 арилжааны банк багтжээ. mongolchamber.mn

05.05 - Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөл 2016 оны 5-р сарын 5-ны өдрийн хуралдаанаар мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар бууруулж 10.5 хувь болгох шийдвэр гаргалаа. mongolbank.mn

05.12 - Монгол Улсын тогтвортой санхүүжилт төслийг дараагийн шатанд ахиулах, ногоон хөгжлийн бодлогыг дэмжих зорилгоор ногоон зээлийн сан бий болгох ажлыг хэрэгжүүлэх “Ногоон зээлийн сангийн ажлын хэсэг”-ийг байгуулж анхны уулзалтыг 2016 оны 5-р сарын 12-ны өдөр зохион байгуулагдлаа. mba.mn

05.23 - Монголбанк арилжааны банкуудын зээлийн тайлангийн маягтыг судалгааны зорилгоор ашигладаг иргэд, байгууллагын хэрэгцээ шаардлага, олон улсын туршлагыг харгалзан шинэчлэн боловсруулав. mongolbank.mn

06.02 – Банкны салбарын ажилтны өдөр болов.


06.13 - Засгийн газар “Сайн хувьцаа” арга хэмжээний хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшдэг иргэдээс тодорхой шалгуурын дагуу 322 ширхэг хувьцааг нэрлэсэн үнээр авахаар болов. Хувьцаагаа зарах сонирхолтой иргэдийн өргөдлийг арилжааны банкуудаар дамжуулан хүлээн авч эхэллээ. zasag.mn

06.29 – Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн саналыг 2016 оны зургаадугаар сарын 29-ны лхагва гарагт боллоо.

06.30 – 2016 оны 3-р сарын 15-ны өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн “Сайн малчин” хөтөлбөрийн хүрээнд нийт 36715 малчинд 141 орчим тэрбум төгрөгийн зээлийг 10%-ийн хүүтэй олгожээ(2016 оны 6-р сарын 30-ны байдлаар). Энэхүү зээлийг Хаан болон Төрийн банкаар дамжуулан олгожээ. mongolbank.mn

Банкны салбарын гол үзүүлэлтүүд


Банкны салбарын актив, их наяд төгрөг



Нийт актив = 23.3 их наяд төгрөг

Салбарын нийт актив 2016 оны эхний улиралд 22 их наяд төгрөг хүрээд байсан бол 2-р улиралд 23 их наядыг давлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 6,8% өссөн үзүүлэлт юм. 2015 оны 3-р улирлаас хойш улирал бүр банкны салбарын нийт актив өслөө.


Нийт зээл ба чанаргүй зээлийн эзлэх хувь



Чанаргүй зээл 6,8%-д хүрлээ.

Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 2014 оны 2-р улирлаас 2016 оны 2-р улирал хүртэл бүтэн 2 жилийн турш улирал бүр өссөөр байна. Чанаргүй зээлийн энэхүү өсөлт нь банкны секторын эрсдэлийг нэмэгдүүлж байна


Ипотекийн зээл, их наяд төгрөг



Ипотекийн зээлийн 77% нь ОСИСТТБХ зээл

Олгогдсон ипотекийн зээл улирал бүр тогтмол өсөж байна. 2016 оны 2-р улирлын байдлаар 3,8 их наяд төгрөгийн зээлийг олгосноос 77% нь буюу 2,9 их наяд төгрөгийн ипотекийн зээлийг орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх (ОСИСТТБ) хөтөлбөрийн дагуу олгосон байна.

Хадгаламж ба харилцах, их наяд төгрөг



Харилцах+Хадгаламж= 10,5 их наяд

Нийт банкны салбарын харилцах ба хадгаламжийн нийлбэр хэмжээ 2016 оны 2-р улирлын байдлаар 10,5 их наяд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс даруй 10%-р өссөн үзүүлэлт юм.


БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2016 он – II улирал




1\$=1965₮ 1¥=298₮

Монголбанкнаас зарласан ханшийн сарын дундаж хөдөлгөөнөөр 2016 оны 6 сарын дундаж Ам.доллар-ын ханш 1965₮, Юань-ийн ханш 298₮ байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Ам.доллар 62 төгрөгөөр өссөн бол Юань-ийн ханш 8 төгрөгөөр буусан байна.




Валют(Харилцах+Хадгаламж) =3,57 их наяд ₮

Банкны салбарын валютын харилцах болон хадгаламжийн хэмжээ өмнөх улиралтай харьцуулахад валютын харилцах 22,6%-иар харин валютын хадгаламж 12,8%-иар өссөн байна.



Ашиг = 29 тэрбум төгрөг

Банкуудын өөрийн хөрөнгө 2016 оны 1-р улиралд бага зэргийн бууралттай байсан бол 2-р улиралд өмнөх улирлаас 177 тэрбум төгрөгөөр өслөө. Банкны сектор 1-р улиралд алдагдалтай гарсан бол 2-р улиралд ашигтай гарав.



Орон нутагт банкны 954 тооцооны төв байна.

Орон нутаг дахь банкны тооцооны төвүүдийн 93% нь Төрийн банк болон Хаан банкны тооцооны төвүүд байна. Бусад банкууд хөдөө орон нутагт нийт ердөө 72 салбар, 56 тооцооны төв ажиллуулж байна.



Банкуудын өрсөлдөөн

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2016 оны 2-р улирлын байдлаар банкны салбарт нийт 14 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Улаанбаатар хотын банк гэсэн 6 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно. Үүнд:

- Нийт актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Ашиг

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-3 банк, бусад банкууд гэж ангилсан.

Энэ удаагийн тайланд Капитал болон Тээвэр хөгжлийн банкны мэдээлэл ороогүй болно.



АКТИВ

БАНКУУД

ТОМ-3 БАНК

>3 их наяд төгрөг

Худалдаа хөгжлийн банк
Хаан банк
Голомт банк

ДУНД-3 БАНК

1-3 их наяд төгрөг

Хасбанк
Төрийн банк
Улаанбаатар хотын банк

БУСАД БАНКУУД

<1 их наяд төгрөг

Капитал банк
Чингис хаан банк
Капитрон банк
Үндэсний хөрөнгө оруулалтын банк
Ариг банк
Богд банк
Кредит банк
Тээвэр хөгжлийн банк







Банкны салбарын төвлөрөл

Зах зээлд эзлэх хувь

Банкны салбарын төвлөрлийг харуулахын тулд Том-3 банкны нийт зах зээлд эзлэх хувийг актив, зээл, хадгаламж ба харилцахын хувьд тус бүр тооцов. Том-3 банкны хувьд салбарын активын 71,6%, хадгаламж ба харилцахын 69%, зээлийн 70,6%-г тус тус эзэлж байна.

Херфиндал Хершман индекс(ХХИ)

ХХИ нь тухайн салбарын өрсөлдөөн болон төвлөрлийг тооцдог олон улсын аргачлал юм. Тооцоходоо тухайн салбарын нэгж бүрийн эзлэх хувийн квадратуудын нийлбэр¹ нь ХХИ болдог. ХХИ 0-1500 хүртэл байвал өрсөлдөөнт, 1500-2500 нь бага өрсөлдөөнтэй, 2500-с их бол төвлөрөл ихтэй хэмээн үздэг.



Том-3 банкны хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад төвлөрөл төдийлөн нэмэгдээгүй байна. Актив болон хадгаламж ба харилцахын хувьд Том-3 банкны салбарт эзлэх хувь бага зэрэг буурсан бол зээлийн хувьд өссөн байна.

ХХИ-г банкны салбарын актив, хадгаламж ба харилцах болон зээлийн хувьд тооцож үзэхэд аль ч үзүүлэлтийн хувьд ойролцоо төвлөрөлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төвлөрөл бага зэрэг ихэссэн байна.


¹ $H = \sum_{i=1}^N s_i^2$, энд s_i нь i нэгжийн салбарт эзлэх хувь

АКТИВ


Тайлант хугацаанд тайланд орсон нийт банкны 12 банкны актив 21,9 их наяд² төгрөгт хүрлээ. Том-3 банк нийт активын 71,6 хувь буюу өмнөх улирлаас 0,2 нэгжээр нэмэгдсэн бол Дунд-3 банк 24,3 хувь, жижиг банкууд 4,1 хувийг эзэлж байна.

ХХБ 6,2 их наяд төгрөгийн актив буюу хамгийн их нь байгаа бол Кредит банк 16,5 тэрбум төгрөгийн актив буюу хамгийн бага нь байна.

Зах зээлд эзлэх хувь, активаар, 2Y'16



Банкуудын активын хэмжээ болон өсөлтийн хувь ()



² Арилжааны банкуудын санхүүгийн хураангуй тайлангийн нийлбэр дүнгээр тооцов. Энэ удаагийн тайланд Капитал болон ТХБ-ны мэдээлэл ороогүй болно.


ЗЭЭЛ

Тайланд орсон 12 банкны нийт зээл 11,1 их наяд төгрөгт хүрлээ. Үүнээс 70.6%-г Том-3 банк, 26.5%-г Дунд-3 банк, 2.9%-г бусад 6 жижиг банкууд бүрдүүлж байна.


Өнгөрсөн улиралд зээл олголтын хэмжээгээр Хаан банк тэргүүлж байсан бол энэ улиралд ХХБ Хаан банкыг гүйцлээ. ХХБ-ны зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.7% өсөдөг байна.

Харин нийт системийн хувьд зээл олголт өмнөх оны мөн үетэй харьцуулахад ердөө 1% өсжээ.


Зах зээлд эзлэх хувь, 2Y'16



Зээлийн хэмжээ болон өсөлтийн хувь ()



Жижиг банкууд




ХАДГАЛАМЖ БА ХАРИЛЦАХ


Тайланд орсон 12 банкны нийт харилах ба хадгаламжийн 69%-г Том-3 банк, 27%-г Дунд-3 банк, 4%-г бусад 7 жижиг банкууд эзэлж байна.

Нийт дүнгээр Хаанбанк салбарын 30.7%-г эзэлж буй нь тэргүүлэх үзүүлэлт юм. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад салбарын хадгаламж ба харилцах 10.2%-иар өслөө.


Зах зээлд эзлэх хувь, 2Y'16



Хадгаламж ба харилцахын хэмжээ болон өсөлт()




Жижиг банкууд




АШИГ

2016 оны 2-р улирлын байдлаар тайланд орсон 12 арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр банкууд нийт 84,2 тэрбум төгрөгийн ашигтай (татварын өмнөх) ажиллажээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 44 хувь буурсан байна.

Банкуудын ашиг, алдагдал:



Жижиг банкууд



Эх үүсвэр:

1. Статистикийн бюллетень, Монголбанк
2. Ипотекийн зээлийн тайлан, Монголбанк
3. Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд, Монголбанк
4. Орон нутгийн банкуудын тайлан, Монголбанк
5. Монголбанкны ханшийн сарын дундаж хөдөлгөөн, Монголбанк
6. Арилжааны банкуудын улирлын санхүүгийн тайлан